

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ ЖИГЖИДСҮРЭНГИЙН
БОЛОРТУЯАГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

НЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрсэн түвшин / Биелэлт /	Хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. "Дэвшилтэд технологид суурилсан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх" зорилтын хүрээнд						
1.1	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, бүртгэлийн талаарх мэдээллийг цахимд байршуулан сурталчлах	Цахимд байршуулсан мэдээллийн тоо	-	УБЕГ болон хэлтсийн цахим сайтаар мэдээллэж байгаа бүртгэлийн үйлчилгээ, цахим үйлчилгээ болон "Мэдээлэл түгээе" аяны хүрээнд хийгдсэн шторк, видео контент, цаг үеийн 50 гаруй мэдээ мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол сурталчилж, байгууллагын вэб хуудсаар сар бүр хуулийн этгээдийн тоон мэдээг хүргэж ажилласан, Аймгийн хэмжээнд "Шинэ хоршоо хөдөлгөөн" хэрэгжиж эхлээд нийт бүртгэгдсэн хоршооны тоо мэдээлэл, Санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй хасагдах жагсаалтад орсон хуулийн этгээдийн мэдээлэл, ТББ-д хуулийн хугацаандаа өнгөрсөн оны үйл ажиллагааны тайлангаа ирүүлэх, Хуулийн этгээд мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаандаа бүртгүүлэх талаар мэдээлэл хүргүүлж ажилласан.	2025.01.02 2025.12.31	100%
1.2	Иргэн, хуулийн этгээдэд Onecall үйлчилгээгээр дамжуулан зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах	Иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллана	-	Байгууллагын мэдээллийн лавлах утас 77060101 onecall үйлчилгээгээр өдөрт 4, сард 88, улиралд 264 иргэн, хуулийн, этгээдэд хуулийн этгээдийн бүртгэл болон иргэний бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг өгч шуурхай үйлчилгээ үзүүлэн ажилласан.	2025.01.02 2025.12.31	100%
1.3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэх талаар ирүүлсэн чиглэлийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Харьяалал харгалзахгүй бүртгэсэн хуулийн этгээдийн тоо	-	Харьяалал харгалзахгүй бүртгэх талаар чиглэл ирүүлээгүй байгаа тул тус ажил хүлээгдэж байна.	2025.07.01 2025.12.31	100%

1.4	Төрийн болон хууль хяналтын байгууллагад цахимаар лавлагаа, мэдээлэл үзүүлэх, хуулбар олгох үйлчилгээ нэвтэрсний дагуу орон нутагт цахимаар үйлчилгээ үзүүлэх	Цаасан болон цахимаар үзүүлсэн лавлагаа, мэдээллийн тоо	-	Цахимаар лавлагаа, мэдээлэл үзүүлэх үйлчилгээ нэвтрээгүй байгаа тул лавлагаа, мэдээллийн үйлчилгээг ERP төрийн мэдээллийн цахим системээр дамжуулан хууль хяналтын байгууллагад лавлагаа, хуулбар 36 олгож, төрийн байгууллагад мэдээлэл хүргүүлж, 6 хуулийн этгээдэд лавлагаа, хуулбар олгож ажилласан.	2025.01.02 2025.12.31	100%
Зорилт 2. "Төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд						
2.1	Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу бүртгэл эрхлэн хөтлөх	Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо	-	Хагас жилийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлсэн байна. - Шинээр байгуулсан хуулийн этгээдийн бүртгэл- 113 - Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл- 174, Үүнээс: - Татан буусан бүртгэл- 1 - Салбар төлөөлөгчийн газар шинээр- 12 - Хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулсан- 279 - Хуулийн этгээдэд шинээр болон дахин олгосон тамга, тэмдгийн бүртгэл- 144 - Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдгийн тоо- 19	2025.01.02 2025.12.31	100%
2.2	Аймаг, сум, хэлтсээс зохион байгуулах "Танд ойрхон төрийн үйлчилгээ" болон "нээлттэй хаалга"-ны өдөрлөг, арга хэмжээ зохион байгуулах	Өдөрлөгт явсан болон мэдээлэл өгсөн иргэний тоо	-	Тус улсын бүртгэлийн хэлтсээс 2025.05.01 өдөр зохион байгуулсан "Танд ойрхон төрийн үйлчилгээ" нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож шинээр 1, мэдээлэлд оруулсан өөрчлөлт 4 болон 13 иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл зөвлөгөө өгч, гарын авлага материал тараан ажилласан. 2025.01.31 өдөр Айраг суманд зохион байгуулагдсан "Малчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцож 16 иргэн, хуулийн этгээдийг зөвлөгөө мэдээллээр хангаж, 4 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тус тус бүртгэсэн.	2025.01.02 2025.12.31	100%
2.3	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах ажлын хүрээнд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, журамд холбогдох саналыг хүргүүлэх	Хүргүүлсэн саналын тоо	-	Тус ажлын хүрээнд дараах эрх зүйн баримт бичигт санал хүргүүлсэн байна. Үүнд: • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль • Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журам • Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам	2025.01.02 2025.12.31	

				- Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэрэг холбогдох хууль, дүрэм, журмын төсөлтэй танилцаж саналыг тус тус хүргүүлсэн.		90%
2.4	Тамга, тэмдгийн журмын дагуу хуулийн этгээдээс тамга, тэмдэг хураан авах, устгах, ажлыг зохион байгуулах, хураан авсан төрийн тамга, тэмдгийг архивт хүлээлгэн өгөх	Тамга, тэмдгийг журамд заасны дагуу хураан авч хагас жил тутамд устгах, архивт шилжүүлсэн тоо	-	Тус аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар нийт 21 хуулийн этгээдээс тамга, тэмдэг хураан авсан байна. Журмын дагуу хагас жилд устгалд оруулж, аймгийн төрийн архивт шилжүүлэхээр төлөвлөж байна.	2025.01.02 2025.12.31	100%
2.5	Орон нутгийн хэмжээнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавих, цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэх	Хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан болон цуцалсан тоо	-	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тогтоол, шийдвэрээр 8 хуулийн этгээдийн улсын бүртгэлд тухай бүр нь хориг тавих, цуцлах арга хэмжээг авч ажилласан.	2025.01.02 2025.12.31	100%
2.6	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхийг холбогдох албан хаагч нарт нээлгэж орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	Хуулийн этгээдийн бүртгэл хийх эрхтэй болсон улсын бүртгэгчийн тоо	-	Шинэ хоршоо хөдөлгөөн эхэлсэнтэй холбогдуулан 2024 оны 05 сард 11 сумын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх шинээр нээж, 2025 онд 2 сумын бүртгэгчид эрх нээлгэх саналыг хүргүүлээд байна, сумдын бүртгэгч нарт 2 удаагийн сургалтаар болон өдөр тутамд арга зүйн зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж, сумын бүртгэгч нар нь иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэж ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	100%
2.7	e-mongolia, e-business.mn төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх	Цахим хэлбэрээр үзүүлсэн үйлчилгээний тоо	-	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia, e-business/-ээс үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хэлтсийн зааланд байрлах e-mongolia төхөөрөмжөөр иргэдэд үйлчилгээ авах талаар зөвлөгөө өгч, сурталчилсан бөгөөд e-business цахим системээр ирсэн 974 хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	100%
Зорилт 3. "Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд						
3.1	Хуулийн этгээдийн мэдээллийн санг цэгцлэх, төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцэлж, зөрчил	-	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим санд байгаа зөрүүтэй мэдээллийн шалган ажиллаж байна. Үүнд: Шилжин ирсэн 3 хуулийн этгээдийн гэрчилгээг буруу гаргасан мэдээллийг Хуулийн этгээдийн газартай холбогдож засах талаар зөвлөмж авсан мөн шилжин ирж		

	этгээдийн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	арилгасан тоо		бүртгэлд хамрагдаагүй 4 хуулийн этгээдтэй холбогдож бүртгүүлэх талаар зөвлөсөн, сумдад бүртгэлтэй төрийн байгууллагуудын удирдлагын өөрчлөлтийг хуулийн хугацаандаа бүртгүүлэх, бүртгэгдсэн эсэх тал дээр хяналт тавьж ажиллах талаар сумдын улсын бүртгэгч нарт мэдэгдсэн. Удирдлагын өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй ЗХ-ний 336 анги, Өргөн сумын соёл, спортын төв, Замын-үүд сумын ЗДТГ, Улаанбадрах сумын ЭМТ, Дэлгэрэх сумын ЗДТГ-ын зөрчлийг хяналтын улсын байцаагчаар зөрчил хянан шийдвэрлүүлж зөрчлийг арилгасан. Мөн тамга тэмдэг үрэгдүүлсэн болон хуулийн хугацаандаа бүртгэлээ хийлгээгүй 3 хуулийн этгээд дээр зөрчил шийдвэрлүүлж, зөрчлийг арилгасан.	2025.01.02 2025.12.31	100%
3.2	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн тоо	-	Эцсийн өмчлөгчийн мэдээллээ бүртгүүлээгүй "Алтанбаян буурал" ХХК, "Гоё мөрөн" ХХК, "Марал шанд" ХХК-ын эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэсэн, "АЕ ложистик" ХХК -н хүсэлтийн дагуу эцсийн өмчлөгчийн мэдээлэл буруу бүртгэгдсэн байсанг үнэн зөв болгож бүртгэсэн. "Энхномин говь", "Гурван баян ширээ" ХХК-ын эцсийн өмчлөлчөө нөхөн бүртгүүлэх талаар мэдэгсэн байна.	2025.01.02 2025.12.31	100%
Зорилт 4. "Хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах" зорилтын хүрээнд						
4.1	Хил орчим болон алслагдмал бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, шинэ хоршоо хөдөлгөөн, бичил уул уурхайн нөхөрлөлүүдийг дэмжих зорилгоор олон талт хамтын ажиллагааг явуулах	Төрийн үйлчилгээний хүртэмжийг нэмэгдүүлэхээр зохион байгуулсан болон хамтран гүйцэтгэмэн арга хэмжээний тоо	-	"Шинэ хоршоо хөдөлгөөн" ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 235 хоршоо шинээр бүртгэгдсэн, 2025 онд бичил уурхайн нөхөрлөл шинээр 16 бүртгээд байна. Алслагдмал Замын-Үүд, Хатанбулаг, Улаанбадрах, Иххэт, Хөвсгөл сумын улсын бүртгэгч нартай хамтран бүртгэл хөтлөн, бүртгэлийн талаар зөвлөгөө, мэдээлэл гарын авлага материалаар хангаж ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	100%
4.2	Төрийн бус байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны тайланг хүлээн авах	Тайлан хүлээн авсан тоо	-	ТББ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан хугацаанд 31 хуулийн этгээдээс тайланг хүлээн авсан байна.	2025.01.02 2025.02.15	100%
4.3	Орон нутгийн хэмжээнд санхүүгийн тайланг 8 ба түүнээс дээж улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн	Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн тоо	-	Санхүүгийн тайланг 8 ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүйгээс хасагдах жагсаалтад орсон хуулийн этгээдийг 2025.05.15 өдөр УБЕГ сайтад зарлаж олон нийтэд мэдээлсэн. Манай харъяалалд бүртгэлтэй 2 хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүргүүлсэн. Мөн хасагдах	2025.01.02 2025.12.31	90%

	этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах			жагсаалтад орсон 4 хуулийн этгээдэд мэдэгдсэн.		
Зорилт 5. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд						
5.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах иргэдэд	Олон нийтэд хүргэсэн тоо	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, видео график, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага зэргийг өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл түгээсэн. авлигаас ангид ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	90%
5.2	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлэх	ХАСХОМ мэдүүлсэн тоо	-	ХАСХОМ-ыг 2025 оны 02 сарын 10 дотор буюу хуульд заасан хугацаанд мэдүүлсэн.	2025.01.02 2025.02.15	100%
Зорилт 6. "Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд						
6.1	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх, шаардлагатай бүртгэлийн мэдээ, тайланг гаргаж, удирдлагыг мэдээллээр хангах	Холбогдох байгууллагуудад мэдээлэл болон тайланг хүргүүлсэн байх	-	Хуулийн этгээдийн бүртгэлийн тоо мэдээ, үнэт цаасны тайланг сар бүр тогтмол гаргаж холбогдох газарт хүргүүлсэн, "Шинэ хоршоо хөдөлгөөнтэй" холбоотой хоршооны талаарх мэдээ, мэдээллийг аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаж байна.	2025.01.02 2025.12.31	90%
6.2	УБЕГ болон байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд тухай бүр оролцох, тайлагнах	Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тухай бүр тайлагнасан байх	-	Зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагаанд тухай бүр оролцсон. 2025.04.09 өдөр Хэлтээс зохион байгуулсан 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид анхаарах асуудлаар зохион байгуулагдсанд сургалтад хамрагдсан. -2025.04.24 аймгийн Эрүүл мэндийн газарт байгууллагын албан хаагч нартайгаа эрт илрүүлэгт хамрагдсан. 2025.05 сард Төрийн тусгай алба хаагдын нэгдсэн эмнэлэгийн үзлэг шинжилгээ эрт илрүүлэгт хамрагдсан. 2025 онд хийгдсэн нийтийн цэвэрлэгээнд 2 удаа оролцсон. 2025 оны 05 сараас эхлэн долоо хоног бүрийн лхагва гарагт хэлтсийн хамт олонтойгоо алхаж байна. - УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан 6 удаагийн онлайн сургалтад хамрагдсан. - Хэлтсийн гадна талбайн хаяг байршуулах, авто машины талбай, боржур будах ажилд хамтран	2025.01.02 2025.12.31	100%

				оролцсон Хэлтсийн алба хаагч, тэдний гэр бүлд тулгарсан бэрхшээлд туслах, дэмжлэг үзүүлэх ажилд оролцож байна.		
6.3	Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" тарих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Тарьж ургуулсан модны тоо	-	2025.05.23 өдөр Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод тарих үндэсний хөтөлбөрийг хүрээнд байгууллагын хамт олонтойгоо Хилэнцэт хөшөөний хашаанд 50 мод суулгах, услах ажилд оролцсон. Мөн өөрийн амьдардаг хорооллын гадаах модыг услаж байгаа.	2025.01.02 2025.12.31	100%
6.4	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнах	Төлөвлөгөөг боловсруулж тогтоосон хугацаанд тайлагнасан байх	-	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргасан.	2025.01.02 2025.12.31	100%
6.5	Аймаг, орон нутгаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу хамтарч ажиллах	Хамтарч ажилласан үйл ажиллагааны тоо	-	Аймаг орон нутгаас зохион байгуулсан дараах арга хэмжээнд чиг үүргийн дагуу ажилласан. 2025.01.31 өдөр Айраг суманд зохион байгуулагдсан "Малчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцож бүртгэл хөтөлж, иргэн, хуулийн этгээдийг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. 2025.04.07 өдөр аймгийн "Татварын газрын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн"-д оролцож хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээ, холбогдох хууль, тогтоомжийн талаар мэдээлэл хийлээ. 2025.05.01 өдөр "Хуульчийн про өдөрлөг"-т оролцож иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгч бүртгэл хийж ажилласан. 2025.05.12 өдөр "Говийн бүсийн зөвлөл"-ийн анхдугаар хуралдааны арга хэмжээнд оролцож иргэдийн бүтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	2025.01.02 2025.12.31	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрсэн түвшин	Хугацаа	
Зорилт 1. Мэдлэг чадварын хувьд ахиц дэвшил гаргаж, шинэ зүйл сурч мэдсэн байх						
1.1	Хүний нөөц, сургалтын нэгдсэн системд тавигдсан сургалт мэдээлэлтэй тухай бүр танилцах	Сургалт мэдээлэлтэй танилцсан байх	-	Сургалтын нэгдсэн системд тавигдсан: -Төрийн албан хаагчдийн харилцаа хандлага ёс зүйн сургалт, -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай мэдээлэл, хичээлийг үзэж танилцсан.	2025.01.02 2025.12.31	90
1.2	Монгол бичиг бие даан суралцах	Мэдлэг чадвар дээшлэх	-	Бие даан анхан шатны монгол бичиг судалж уншиж сурч байна.	2025.01.02 2025.12.31	80

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭГЧ
(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

Ж. БОЛОРТУЯА / 2025.06.09
(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

/С.ЭНХ-ЭРДЭНЭ/
(Огноо)



**ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН
УЛСЫН БҮРТГЭГЧ (албан тушаалын нэр)
Жигжидсүрэнгийн Болортуяа (албан хаагчийн овог, нэр)-н
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
1.	Зорилт 1 ““Дэвшилтэд технологид суурилсан төрийн цахим үйлчилгээ” зорилтын хүрээнд	57	10	67	
2.	Зорилт 2 “Төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд	50	10	60	
3.	Зорилт 3 “Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд	55	10	65	
4.	Зорилт 4 “Хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах” зорилтын хүрээнд	55	10	65	
5.	Зорилт 5 “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд	55	10	65	
6.	Зорилт 6 “Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд	55	10	65	
Дундаж оноо:				64.5	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4

1.	Хүний нөөц, сургалтын нэгдсэн системд тавигдсан сургалт мэдээлэлтэй тухай бүр танилцах	90	13.5	13.5
2.	Монгол бичиг бие даан суралцах	90	13.5	13.5
Дундаж оноо				13.5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	5	5
2.	Дүн шинжилгээ хийх	5	5
3.	Асуудал шийдвэрлэх	4	4
4.	Хариуцлагатай байдал	5	5
5.	Ажлын цаг ашиглалт	5	5
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	5	5
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	5	5
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	5	5
Дундаж оноо		4.9	4.9

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	64.5
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	4.9
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		90.9

Үнэлгээ өгсөн:

Хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга



/ С.Энх-Эрдэнэ /

(албан тушаал)

(гарын үсэг)

(албан хаагчийн нэр)

2015.06.18
..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Улсын бүртгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/ Ж.Болортуяа /
(албан хаагчийн нэр)

2015.06.18
..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Иргэний улсын ахлах бүртгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/ Б.Баттуяа /
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Бичиг хэргийн эрхлэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/ Н.Цэндмаа /
(албан хаагчийн нэр)

2015.06.18
..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/ С.Энх-Эрдэнэ /
(албан хаагчийн нэр)

2015.06.19
..... (огноо)

